

# БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

## Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

### Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг хоёр удаа хийж, 5 асуудал хэлэлцэн, 6 тогтоол гаргалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын ирц 65,0-91,0 хувь байлаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит 10-р хурлаар Булган аймгийн ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн ээлжит XV хуралдааныг Булган суманд хуралдуулахаар шийдвэрлэлээ.

Булган аймгийн ИТХ-ын 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн тухай, аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020-2024 онд хөгжүүлэх чиглэлд санал өгөх тухай зэрэг асуудал хэлэлцэхээр төлөвлөв.

Аймгийн ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн XV хуралдааныг 9-р сарын 18-ны өдөр хуралдуулж 6 асуудал хэлэлцлээ. Булган аймгийн ИТХ-ын 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн тухай, аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020-2024 онд хөгжүүлэх чиглэлд санал өгөх тухай зэрэг асуудал “Авто зам, төмөр замын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг тогтоох тухай” асуудлыг хэлэлцлээ. Хуралдаанаас 7 тогтоол гаргалаа

### Төрийн захиргааны чиглэлээр:

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж 3 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Булган, Бугат, Дашинчилэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 6 иргэн оролцлоо.

### Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

**Татварын чиглэлээр:** 2020 оны эхний 9 сарын байдлаар өссөн дүнгээр улсын төвлөрсөн төсөвт 514,620,0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 577,688.0 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг **112.3%**, аймгийн төсөвт 13,818,900.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 14,044,174.0 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг **101,6%**, сумын төсөвт 1,259,488.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 1,782,375.0 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг **141,5%** хувь, нийт улс, аймаг, орон нутгийн төсөвт 15,593,008,0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 16,404,237,0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг **105.2** хувиар биелүүлэн ажиллалаа.

Тайлант сард өмнөх оны нийт 2,005,692.7 мянган төгрөгийн татварын өрөөс 49,541.4 мянган төгрөгийг, тайлан оны нийт 1,303,973.2 мянган төгрөгийн өрөөс 165,945.8 мянган төгрөгийг тус тус барагдуулаад байна.

**Санхүүгийн хяналтын чиглэлээр:** Бугат сумын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийлээ. Шалгалтаар дараах төлбөр тогтоолоо. Үүнд:

- 1.Орон нутгийн төсөвт байгууллагуудад 5506,0 мянган төгрөг
2. Ерөнхий боловсролын сургуульд 868,7 мянган төгрөг
3. Цэцэрлэгт 167.7 мянган төгрөг
4. соёлын төвд 374,4 мянган төгрөг
- 5.Эрүүл мэндийн төвд 2497,7 мянган төгрөг нийт 9040.1 мянган төгрөгийн төлбөр тогтоолоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх “Ханжаргалант багийн эрчим хүчний шугам”-ын 41,0 сая төгрөгийн асуудал шүүхийн шатандаа шийдвэрлэгдээгүй байна.

Өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлийг шийдвэрлүүлэхээр хууль хяналт байгууллагад шилжүүлэв.

### **Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

“Малын хулгайн гэмт хэргийг бууруулахад хамтын оролцоо” сэдэвт зөвлөгөөнийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, мал сүргийг хулгайн гэмт халдлагаас хамгаалах монголын нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа. 7 сумын 6 баг, 1 тосгоны 351 иргэнд 770 ш тараах материал тараасан.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 09 дүгээр сард 3 сумын Засаг даргын 125 захирамж, 42 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Прокурорын газар, Хилийн цэргийн 0286 дугаар анги, Хорих 439 дүгээр ангиудад нийт 56 000 000 төгрөгийн хөрөнгийг шийдүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 30 иргэн үйлчлүүлж хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 09 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулахад 301 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 78 хэргээр буюу 20.6 хувиар буурсан. Илрүүлэлтийн хувь 46.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сайхан, Сэлэнгэ, Хялганат, Бүрэгхангай, Хангал, сумдад урьд оны мөн үеэс өсч, Гурванбулаг, Баяннуур, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Дашинчилэн, Рашаант Баян-Агт, Булган сумдад урьд оны мөн үеэс буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 64 бүртгэгдэж 11 хэргээр буюу 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй.

### **Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

#### **Боловсролын чиглэлээр:**

#### **Хамран сургалтын тоо өсч байна**

Булган аймгийн 2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 115 бүлэгт (3-5 нас) 2600 хүүхэд, 117 үндсэн багш, 116 туслах багш, ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн 387 бүлэгт 11906 сурагч (1-р ангид 1406 сурагч), 605 үндсэн багш ажиллаж байна.

#### **Боловсролын салбарын удирдах ажилтны бага хурал**

2020-2021 оны хичээлийн жилийн боловсролын салбарын удирдах ажилтны бага хурал амжилттай зохион байгуулагдаж, тус хурлаар өнгөрсөн оны хичээлийн

жилийн ололт амжилт, алдаа дутагдлыг ярилцан энэ хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлэлцэн баталлаа.

Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан МХГ, ОБГ, ЭМГ мэдээлэл хийж БСШУСЯ-ны А/140 "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж", А/17 "Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээ"-г хэлэлцэн дадлага ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Мөн энэ үеэр БШУЯ-ны "Багш бүрийг компьютержуулах" хөтөлбөрийн хүрээнд нийт 85 зөөврийн компьютерыг СӨББ, ЕБС-иудад гардуулахаас гадна Ухаалаг анги төслийн хүрээнд нийт 5 сургуульд Дижитал ангийн тоног төхөөрөмжийг гардууллаа.

#### **Бүсийн сургалтыг 4 бүсэд амжилттай зохион байгууллаа**

Чин толгой бүсийн сургууль, цэцэрлэгийн 150 гаруй багш, удирдах ажилтнууд "Багш, ажилтныг чадваржуулах" сургалтыг Дашинчилэн суманд 2020 оны 9 дүгээр сарын 5~6-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Булган хан бүсийн төлөөлөн Булган аймгийн ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш, удирдах ажилтнууд "Багш, ажилтныг чадваржуулах" сургалтад 2020 оны 9 дүгээр сарын 7~11-ны өдрүүдийн хичээлийн бус цагаар хамрагдлаа.

Дархан хан бүсийн сургууль, цэцэрлэгийн 100 гаруй багш, удирдах ажилтнууд "Багш, ажилтныг чадваржуулах" сургалтыг Бүрэгхангай суманд 2020 оны 9 дүгээр сарын 11~12-ны өдрүүдэд зохион байгууллаа.

"Сэлэнгэ" бүсийн сургууль, цэцэрлэгийн 136 багш, ажилтан хамрагдсан "Багш, ажилтныг чадваржуулах" сургалтыг Сэлэнгэ суманд 2020 оны 9 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалтаар мэдээлэл харилцааны технологийг ашиглах нь, судалгаа шинжилгээ хийх, сургалтын шинэлэг арга зүйд суралцах, хичээлийн судалгаа, даалгаварт суурилсан оношлох арга зүй, нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөрийг үнэлгээтэй хэрхэн уялдуулах, хичээл хоорондын залгамж холбоог хэрхэн гаргах, судлагдахуун тус бүрээр 2020~2021 онд зохион байгуулах үйл ажиллагаандаа багш нарынхаа саналыг тусгаж, багшийн сургалтын үйл ажиллагаагаа хэрхэн оновчтой зохион байгуулах чиглэлээр сургалтыг зохион байгууллаа.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

- ЭМЯ-ны "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ЭМБ-уудын мэдээллийг бүртгэх tz.mohs.mn программын цахим сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдав.
- ЭМБ-уудад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ХЧТА-ын судалгааг хийн, холбогдох байгууллагад хүргүүлсэн.
- ЭМЯ-аас Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд /DAFI MAE/020 covid-19/ төслөөр ирсэн 4 төрлийн тоног төхөөрөмж, урвалж, бодисыг хүлээн авч АНЭ-ийн тасаг нэгжүүдэд хүлээлгэн өгсөн.
- Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлын үнэлгээг 1,7-р цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хийж мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.
- Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 04 дүгээр хурлаар 5 эрүүл мэндийн байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлын тэмдэглэл, холбогдох материалыг АЗДТГ-т хүргүүлсэн.

- “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” 3 сарын аяны нээлтийг ЭМГ, АНЭ, Сум, Өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, эмч мэргэжилтнүүдийг оролцуулан аймгийн хэмжээнд онлайнаар зохион байгуулсан.
- ЭМЯ, ДЭМБ болон Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн хамтарсан багийн дэмжлэгт хяналт үнэлгээнд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Эмийн цэцэглэн, Цоожэд ӨЭМТ, Баян-агт сумын сумын ЭМТ-үүд 2020 оны 09 сарын 15-наас 18-ны өдрүүдэд хамрагдсан.
- Хамтарсан багийнхан COVID-19 цар тахлын үед тусламж үйлчилгээг үзүүлэхэд баримтлах халдварын сэргийлэлт, хяналт болон эх хүүхдэд үзүүлэх нэн шаардлагатай тусламж үйлчилгээг цар тахлын үед тасралтгүй хүргэх чиглэлээр зөвлөгөө зөвлөмжийг өгч, 26 эмч мэргэжилтэнд Коронавируст халдвар (#COVID19)-ын үеийн бэлэн байдал, жирэмсний хяналт болон эхээс хүүхдэд ХДХВ, Гепатит В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихаас сэргийлэх чиглэлийн 1 өдрийн сургалт зохион байгууллаа.
- АНЭ, 16 сумын ЭМТ-ийн түргэн тусламжийн дуудлагын 18 жолооч нарт “Амь тэнсэн үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх” чиглэлээр сургалт зохион байгуулж тусламж үйлчилгээ үзүүлэх арга барилд сургаж, дадлагажуулан автомашины бэлэн байдлыг шалган, мэргэжил арга зүйгээр хангасан.
- Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах 23 эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг гарган, ЭМХТ-д хүргүүлсэн.
- 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг хэлэлцэх хурлыг 2020 оны 09 сарын 22 ны өдөр зохион байгуулж, хурлын тэмдэглэл, холбогдох материалыг ЭХЭМҮТ-д хүргүүлсэн.
- АНЭ, Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв дээр 09 сарын 24-26 ны өдрүүдэд 7 чиглэлээр нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, мэс засал хийх хугацааг төлөвлөсөн.
- Ахмадын эрүүл мэндийг дэмжих” сарын аянаар ЭМГ, Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, НЭ-ийн ахмадын эмч, сувилагч нартай хамтран Булган сумын 4.5-р бүлгийн хүнд, хэвтрийн 26 ахмадуудыг гэрээр эргэлт хийн, гериатрийн эмчийн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, 3 төрлийн витаминжуулалт хийн хамтран ажилласан.
- Байгалийн болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үзлэгийг Могод суманд, команд шатабын үзүүлэх сургуулалтыг Бүрэгхангай суманд зохион байгуулж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:**

"Булганхангай" МСҮТ-д шинээр элсэн суралцаж байгаа оюутнуудад хувь хүний хөгжил, хандлагын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 30 оюутан хамрагдсан ба сургалтын үеэр байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулж, кино үзвэрийн үйлчилгээ үзүүллээ.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй залуучууд, оюутан сурагчдад зориулсан “Чөлөөт индэр” уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад оролцогчдод хэрэглээгээ ухаалгаар удирдах, ярих урлаг, цахим нүүдэл сэдвээр ярилцаж санал бодлоо солилцлоо. Уулзалтад нийт 50 залуучууд хамрагдсан.

Ирээдүй эзэд мэргэжил сонголтын аяны хүрээнд АНУ-д суралцдаг Булган аймгийн оюутнуудын төлөөлөл Булган сумын ЕБС-уудын 11, 12 ангийн сурагчдад гадаадад хэрхэн суралцах вэ, гадаад улсад тэтгэлэгт хэрхэн хамрагдах вэ, хэрхэн сайн оюутан байх вэ сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 150 гаруй

хүүхэд оролцож өөрсдийн сонирхсон асуултад хариулт авлаа. Сурагчдын идэвхи оролцооноос харахад хүүхдүүд гадаадын их дээд сургуульд суралцах хүсэл их байгаа нь илэрхий байлаа.

Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордонд 4 төрлийн дугуйлан клубд хүүхдийг ажлын 5 өдрийн хуваарийн дагуу хамруулж ажиллаж байна. **Үүнд:**

- Хүүхдийн оролцооны байгууллагын нийт 12 хүүхэд ажлын 3 өдрөөр, давхардсан тоогоор 144 хүүхэд.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх төвд ажлын 5 өдрөөр 5хүүхэд, давхардсан тоогоор 100 хүүхэд.
- Соробан сампин, баруун тархи хөгжүүлэх сургалтад 14 хүүхэд ажлын 4 өдрөөр хичээллэж, давхардсан тоогоор 224хүүхэд.
- Теннисний секц 26 хүүхэд ажлын 4 өдрөөр хичээллэж, давхардсан тоогоор 416 хүүхэд тус тус хамрагдаж, нийт 884 хүүхэд хөгжлийн ордны үйлчилгээнд хамрагдсан байна.

Аймгийн хүүхдийн парламентын хүүхдүүдийн санаачилгаар “Өв соёлоо түгээн дэлгэрүүлцгээе” уриатай сарын аян зарлагдаж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан аймгийн БСУГ- тай хамтран дараах 4 ажлыг өрнүүлж эхлээд байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-ийн 1-12 дугаар ангийн бүх сурагчдын хичээлийн дэвтрийн хаягжилтыг монгол бичгээр солих “**Босоо бичигт монгол хүн**” давалгааг санаачлан Баян-Агт, Баяннуур, Хутаг – Өндөр, Булган сумын 3 сургууль зэрэг 4 сум, 7 сургуульд хэрэгжиж эхлээд байна.

Төрийн албан хаагчдыг нэрийн хуудасжуулах аян өрнүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байгаа бөгөөд нэрийн хуудас нь **Монгол бичиг, Англи** гэсэн 2 хэлээр бичигдэх бичвэрийн эх бэлтгэлийн ажил эхний шатандаа явж байна.

Монгол хэлний хэлц үгийн утгыг хүүхэд өсвөр үеийнхэнд таниулах зорилгоор “**Чөлөөт асуулт**” богино хэмжээний нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэж ажиллаа.

## **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

### **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 9-р сарын байдлаар 1887 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 92 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийт 23 иргэнд гарган Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Ажил олгогч 13 байгууллагаас 281 ажлын байрны захиалга авч, орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурталчилгааг явуулж, 69 иргэнийг улирлын болон түр ажлын байранд зуучлан ажиллалаа.

**Шинэ ажлын байр:** Шинээр бий болж байгаа ажлын байранд 31 иргэн орж ажилласнаас байнгын ажлын байранд 4 иргэн, улирлын ажлын байранд 11 иргэн, түр ажлын байранд 16 иргэн тус тус зуучлагдан ажиллаж байна.

**Ажилд зуучлагдсан иргэн:** Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд **69** иргэн ажлын байранд зуучлагдснаас байнгын ажлын байранд 2 иргэн, улирлын ажлын байранд 14 иргэн, түр ажлын байранд 53 иргэн тус тус зуучлагдан ажиллаж байна.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэн 10 иргэнийг түр ажлын байраар ханган тэдгээрийн ажлын хөлсөнд 2,4 сая төгрөгийг зарцуулсан. Ургац хураалттай холбоотой бий болж буй түр ажлын байруудад иргэдийг зуучлан, ургац хураалтын үед ажиллах иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд байгуулах хөдөлмөрийн түр гэрээ байгуулж байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо

тариалах арга хэмжээнд ургац хураалттай холбоотой зардлуудын баримт материалуудыг сумдаас бүрдүүлэн авч байна.

“Булганд үйлдвэрлэв” дэлгүүрт 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэний 28 нэр төрлийн бараа борлуулагдаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх сургалтад 9 залуучуудыг хамруулсан.

Байгууллагын хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх мэдээллийг шилэн дансны мэдээлэлд оруулж баталгаажуулав.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 35 иргэнд өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Өссөн дүнгээр ганцаарчилсан зөвлөгөөг 336 иргэнд үзүүлсэн байна. Сарын мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор гарган ХХҮЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Сайхан Монгол ТВ-тэй хамтран ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор ажилгүй иргэдэд “Ажилд ороход анхаарах асуудал, ажил хэрхэн хайх” талаар мэдээлэл хийв.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийг ургац хураалтын үед ажиллахад зориулан ХАБЭА-н зөвлөмж гарган, нийт сумдад зөвлөмжийг хүргүүлсэн.

Булган сумын Засаг даргын тамгын газрын ажиллагсдад “Хөдөлмөрийн эрүүл мэнд” сэдвээр сургалт явуулж, 34 ажилтныг хамруулав.

Нийт 34 төрлийн тендерийн ажилд 87 компанитай ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулан ажиллалаа.

#### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Халамжийн сангаас 2020 оны 9-р сард 2420 иргэнд 511,9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгогдсон. Бүх сумдаас тэтгэвэр тэтгэмжийн хувийн хэрэг, нэг удаагийн хөнгөлөлтийн материалыг хүлээн авч хянан, олголтыг хийсэн. Мөн УБГ-аас нас барсан иргэдийн жагсаалтыг авч 45 иргэнийг WAIS програмд тулгалт хийн, 16 иргэний үйлчилгээг зогсоов. Халамжийн сангийн олголтын талаар мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 228 иргэн /үүнээс өргөдөл-1/, утсаар холбогдсон 37 иргэн, ЕНАЛАМJ систем, ӨМНС, хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал болон бусад үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 93 иргэн, утсаар холбогдсон 106 иргэний асуудлыг шийдвэрлэн, хариу өглөө.

Халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд улсын төсвөөс 2020 оны 9 сарын байдлаар нийт 5.165,8 сая төгрөгийн санхүүжилт авахаас 5.937,8 сая төгрөгийн санхүүжилт авч, 23790 иргэнд дараах үйлчилгээнүүдийг үзүүллээ.

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 1158 хүнд 1.896,6 сая төгрөг
  - Нийгмийн халамжийн тэтгэмж 1584 хүнд 989,9 сая төгрөг
  - Жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 1105 хүнд 137,1 сая төгрөг
  - Цалинтай ээжийн хөтөлбөрийн хүрээнд 3160 эхэд 1.014,9 сая төгрөг
  - Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж 101 хүнд 80,2 сая төгрөг
  - Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 1200 хүнд 152,5 сая төгрөг
  - ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт тусламж 285 хүнд 42,1 сая төгрөг
  - АЦА настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 29 хүнд 36,4 сая төгрөг
  - Алдарт эхийн 1,2-р одонтой эхчүүдийн мөнгөн тусламж 5507 хүнд 705,3 сая төгрөг
  - 65-аас дээш настай ахмадуудад насны хишиг олголт 3505 хүнд 524,6 сая төгрөг
  - Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1471 хүн 522,9 сая төгрөг

- Ихэр хүүхдийн тэтгэмж 5 хүнд 10,0 сая төгрөг, нийт 5.662,4 сая төгрөг олгосон байна.

Орон нутгийн халамжийн сангаас 2020 онд 79,2 сая төгрөгийн санхүүжилт авахаас бүрэн орж ирсэн бөгөөд 9 иргэнд дараах үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна. Үүнд:

- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны 4 иргэнд 4,8 сая төгрөг
- Гэр оронгүй болсон өрх, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон 3 өрх-иргэнд 3,6 сая төгрөг

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

#### **Мал аж ахуйн талаар :**

Аймгийн хэмжээнд малчдын хүчээр 111.2 мянган тн байгалийн хадлан, 1.2 мянган тн ногоон тэжээл, 8.4 мянган тн үйлдвэрийн тэжээл, 1.6 мянган тн гар тэжээл, 10.1 мянган тн давс хужир, шүү бэлтгэхээс 63139 тн байгалийн хадлан, 60 тн ногоон тэжээл, 20 тн үйлдвэрийн тэжээл, 729 тн гар тэжээл, 91 тн хужир шүү бэлтгэж, бэлтгэвэл зохих хадлангийн 42.3 хувийг бэлтгээд байна.

Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолоор аймаг 770 тн өвс, 150 тн тэжээл, сумдууд 100 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэхээс аймгийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 2370 тн өвс, 790 тн тэжээл бэлтгэсэн мэдээг 9 дүгээр сарын байдлаар нэгтгээд байна.

Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумд 100 хувь, Баяннуур, Гурванбулаг, Дашинчинлэн, Могод, Орхон, Рашаант, Хишиг-Өндөр сумд 10 хүрэхгүй хувийг бэлтгэж байна. Урд бүсийн сумдын малчид 7000-8000 төгрөгөөр өвс худалдан авч байна. Мөн ногоон тэжээл хураах үед малчид худалдан авалт хийнэ.

Аймгийн өвс, тэжээлийн нөөц бэлтгэх ажлыг “Шинэ хөдөө-Хөгжил” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, одоогийн байдлаар 850 боодол өвсийг өөрсдийн хүчээр, иргэн Ц.Болдбаатартай гэрээ байгуулж 1500 боодол өвс бэлтгээд байна.

Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бэлтгэх хөрөнгийг сумаар нь авч үзвэл: Баяннуур 4.6 сая, Бугат 12.0 сая, Булган 22.0 сая, Бүрэгхангай 15.4 сая, Гурванбулаг 29.5 сая, Дашинчилэн 7.7 сая, Могод 6.0 сая, Орхон 13.0 сая, Сайхан 17.0 сая, Тэшиг 5.3 сая, Хангал 7.5 сая, Хишиг-Өндөр 20.0 сая, Хутаг-Өндөр 4.0 сая, нийт 164.0 сая төгрөг байна.

“Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд зөгий гэрээгээр авсан, үржүүлэх сонирхолтой Булган, Бугат, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хангал, Тэшиг сумын зөгийчдөд зориулсан сургалтыг Бугат сумын “Даваат булаг”-т зөгийн аж ахуй эрхлэгч н. Цогтсайханы өрхийн аж ахуйг түшиглэн зохион байгуулав. Тус сургалтад Аймгийн ЗДТГазар, ХХААГазар, МСҮТөвийн багш, мэргэжилтнүүд 11, мөн зөгий үржүүлж буй 35, нийт 46 хүн оролцлоо. Хөтөлбөрт тусгагдсан агуулгын хүрээнд сургалтын материалуудыг боловсруулан гарын авлага болгон өглөө.

Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дугаар зүйлийн 6.4.11 дүгээр зүйлийн 11.6 11.6.3, УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.2.1, Хүнс хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-112 дугаар тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны А-209 дугаар захирамж гарган ажлын хэсэг томилон Сайхан, Могод сумдын 152 малчин өрхийн 9.8 мянган адуунд үзлэг ангилалт хийж, 5.0 мянган адууг цөм сүргээр бүртгэж тэмдэглэв.

Архангай аймагт зохион байгуулагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн хүрээнд “Эрүүл бэлчээр - Эрүүл мал -

Эрүүл хүнс” сэдэвт төвийн бүсийн 7 аймаг оролцсон зөвлөгөөнд 16 сумын мал зүйч, бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн нар оролцов.

Зөвлөгөөний үеэр Малын үржил чанар, эрүүл бэлчээр, эрүүл мал гэсэн 3 хэсэг хэлэлцүүлэг болж, холбогдох илтгэл мэдээлэлтэй холбоотой санал хүсэлтийг сонссон ажил хэрэгч зөвлөгөөн болсон. Мөн малын тэжээлийн чанар, хангамжийг нэмэгдүүлэх, мал сүргийн ашиг шим, тэсвэрт чанарыг сайжруулах, сүргийн эргэлтийн тооцооллын дагуу бэлчээрийн даацад тохируулах зэрэг ажиллагааг БАХ, малчдыг бүлэг, малчин өрхийн түвшинд хэрэгжүүлж байгаа ажлын явцтай танилцсан.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумдаас эрчимжсэн махны, сүү-махны үхэр, нарийн нарийвтар ноост хонь, тахиа, зөгийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн судалгааг гаргаж, ХХААХҮЯамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.

Хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 30 худаг 510 сая төгрөгийн нээлттэй тендер зарлагдаж “Булган Ус” ХХК, “БИММ” ХХК, “Таширын хүрээ” ХХК-иуд шалгарч гэрээ байгуулан ажлаа гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар шинээр 21 худаг гаргаад байна. “Булган Ус” ХХК 16 худаг гаргахаас 12 худаг, “БИММ” ХХК 7 худаг гаргахаас 4 худаг, “Таширын хүрээ” ХХК 7 худаг гаргахаас 5 худаг гаргаад байна.

#### **Хүнс, газар тариалангийн талаар:**

9-р сард Ургац хураалтын бэлтгэл ажлыг шалгах, хураан авах ургацын хэмжээг таримлын нэр төрлөөр тогтоох, үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгааг 7 сумын 15 аж ахуйн нэгжийн 2911 га талбайд хийсэн. Энэ талбайгаас 3500-4000 тн үр нөөцлөх боломжтой. Ургацын урьдчилсан балансаар үр тариа 38264 га-аас 51360 тн, буудай 37350 га-аас 50187 тн буюу 13,4 цн, бусад үр тариа 914 гаас 1172 тн, малын тэжээл 2650 га-аас 4040 тн, тосны ургамал 4887 га-аас 2644 тн, төмс 552 га-аас 5256 тн буюу 95,0 цн, хүнсний ногоо 156 га-ас 127,3 цн буюу 2000 тн-ыг хураан авах төлөв гарсан.

09 дүгээр сарын 30-ны байдлаар үр тариа 10200 га хурааж 11560 тн, төмс 210 га хурааж 2000 тн, хүнсний ногоо 101 га хурааж 900 тн, ногоон тэжээл 1000 га хурааж 1500 тн хураан авч, үр тарианы 26,6%, төмсний 38 хүнсний ногооны 70,0 хувьтай тэнцэх хэмжээний талбай хураагаад байна.

Улсад хүнсний зориулалтаар 2560 тн буудай тушаасан байна. Тушаасан буудайн чанар I, II ангид тэнцэж байна.

Ургац хураалтын ажилд аймгийн төвийн МСҮТ болон ХААИС-ийн 50 гаруй оюутан намрын ажил гүйцэтгэж баяна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нарийвчилсан судалгаанд тэнцсэн 1.1 тэр бум төгрөгийн 15 төслийн мэдээллийг авч Аймгийн Дэд хорооны хурлыг хуралдуулан онооны эрэмбээр жагсаан аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүллээ.

BEST-хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран Сайхан суманд “Сум хөгжүүлэх сан”-гийн зээлд хамрагдах хүсэлтээ өгсөн бизнес эрхлэгч 15 иргэнд төсөл хэрхэн бичих сэдэвт сургалт зохион байгуулаа.

#### **Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр:**

#### **Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

##### **Газар зохион байгуулалтын чиглэлээр**

Бугат, Булган, Гурванбулаг, Могод, Рашаант, Орхон, Сэлэнгэ, Сайхан, Тэшиг, Хутаг-Өндөр сумд 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний



тодотгол болон 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан сумын ИТХ-раа батлуулаад байна.

“Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” /Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг/ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер 2020 онд зарлагдаж, мэргэжлийн “Вектор мэл” ХХК шалгаран Сумын Засаг даргын 2020 оны А/375 дугаар захирамжаар гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгосон тул “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах 93 дугаартай ажлын гэрээг 2020 оны 09-р сарын 09-ны өдөр батлагдсан.

2020 оны 3-р улирлын байдлаар **65** иргэн өргөдөл ирүүлснээс **26** иргэнд **3.86** га газрыг өмчлүүлж, өссөн дүнгээр **15159** иргэн өргөдөл ирүүлснээс **15120** иргэнд **2449.30** га газрыг өмчлүүлж статистикийн 2018 оны 62214 иргэнд харьцуулахад 24.3 хувьтай газар өмчлөлийн ажил явагдаж байна. Сумдаар авч үзвэл: Булган сум **7** иргэнд **0,65** га, Орхон **2** иргэнд **0,11** га, Сайхан **4** иргэнд **0,5688** га, Тэшиг **4** иргэнд **0,69** га, Хутаг-Өндөр сум **9** иргэнд **1,85** га газрыг өмчлүүлсэн бусад сумд газар өмчлөх шийдвэр гаргаагүй байна. Мөн Засгийн газрын 2020 оны 170 дугаар тогтоолоор одоо эзэмшиж байгаа хашааны 168 иргэний 25,92 га газрыг өмчлүүлэхээр батлагдаж, шинээр өмчлүүлэхээр төлөвлөгдсөн 692 иргэний 86,34 га газар батлагдаагүй хасагдсан болно.

#### Газрын татвар төлбөр үнэлгээний чиглэлээр

2020 оны 01-р сарын 1-нээс эхлэн төсвийн тухай хуулийн дагуу аймгийн төрийн санд газрын төлбөрийн орлогын 60%, сумын төсөвт 40% төвлөрөхөөр хуульчлагдсан.

Аймгийн хэмжээнд 2020 онд газрын төлбөрт 505 сая, дуудлага худалдаанд 20 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 09-р сарын 30-ны байдлаар [mof.gov.mn](http://mof.gov.mn) сангийн яамны сайтаас авсан орлогын дүнгээр аймгийн төрийн санд 478.3 сая төгрөг төвлөрч үүнээс газрын дуудлага худалдаанд 138,8 сая төгрөг төвлөрсөн. Харин сумдад төвлөрч байгаа газрын төлбөрт нийт 40,5 сая төгрөг төвлөрсөн мэдээлэлтэй. Дээрхээс үзэхэд газрын төлбөр, дуудлага худалдаанд нийт 525 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 518,8 сая төгрөг төсөвт төвлөрсөн дүнтэй байна.

Газрын дуудлага худалдааг газрын биржид мэдээлэн зохион байгуулж байгаатай холбоотой 2020 оны 09-р сарын 24-ны байдлаар өссөн дүнгээр тус цахим системд газар эзэмшүүлэх дуудлага худалдаагаар нийт 96 нэгж талбарын газар зарлагдсанаас танхимын хэлбэрээр 24 нэгж талбарт, цахим хэлбэрээр 72 нэгж талбарын газруудад дахин болон хэвийн байдлаар зарлагдан зохион байгуулагдсан. Үүнээс 9 нэгж талбарын газар худалдаалагдаж төсөвт 138,8 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

2018-2020 онд газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн иргэд аж ахуйн нэгжийн нийт 766 нэгж талбарын газарт татвар ногдуулсан байна. Тус судалгааг маягтын дагуу сумдаас авч нэгтгэн Татварын хэлтэст 2020 оны 01/934 тоот албан бичгийн дагуу хүргүүлэ

#### Барилга хот байгуулалтын чиглэлээр

Сэлэнгэ сумын 75 ортой шинэ цэцэрлэг ашиглалтад орж, бяцхан эздээ хүлээн авч байна. Орон нутгийн төсвийн 792.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2019 онд баригдаж эхэлсэн тус цэцэрлэгийн гүйцэтгэгчээр "Манхан уст" ХХК ажиллаж, гэрээт хугацаанаасаа өмнө хүлээлгэн өглөө.

Аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 1,077,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй "Бялзуухай" цэцэрлэгийн 120 ортой өргөтгөлийн барилгыг Орхон аймгийн "Борхууд" ХХК барьж дуусган хүлээлгэн өгч нээлтээ хийлээ.

Ардын Хатанбаатар Магсаржавын нэрэмжит Хутаг-Өндөр сумын сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга ашиглалтад орж, 3 ээлжээр

хичээллэж байсан сурагчид хоёр ээлжээр хичээллэх боломжтой боллоо. 95 жилийн түүхтэй тус сургуулийн өргөтгөлийн барилгыг улсын төсвийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Алтайн бумбат өргөө” ХХК барьж хүлээлгэн өглөө.

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**